



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 17 -ны өдөр

Дугаар 1/77

Эрдэнэт

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах заалт, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Засгийн газрын 2017 оны “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 289 дүгээр тогтоол, Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 30 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. “Халдварт бус өвчинтэй тэмцэх аймгийн дэд хөтөлбөр”-ийг хариуцлагатай, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. “Халдварт бус өвчинтэй тэмцэх аймгийн дэд хөтөлбөр”-т тухай бүр үнэлгээ дүгнэлт хийж хэрэгжилтийг хангуулж ажиллахыг хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн / Г.Энхжаргал/- д даалгасугай.

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны  
08 дугаар сарын 11-ны өдрийн  
1177 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



### **АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Ажлын хэсгийн дарга: - Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга
- Гишүүд:
- Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ хариуцсан ажилтан
  - Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан ажилтан
  - Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт, осол гэмтэл хариуцсан ажилтан
  - Амны хөндийн эрүүл мэнд хариуцсан ажилтан
  - Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан ажилтан
  - Мэдээлэл сургалт сурталчилгаа хариуцсан ажилтан
  - Зураглаач
- Нарийн бичгийн дарга: - Халдварт бус өвчний тандалт сэргийлэлт хариуцсан ажилтан